



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26-ны өдөр

№ 2025/13

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн эцнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн өмчлөх бусад хөрөнгөд бүртгэгдсэн Хан-уул дүүрэг, 1 дүгээр хороо, Ратид хотхон, 8 байр, 64 тоот хаягт байрлах 107.81 мкв талбайтай, улсын бүртгэлийн Y-2206016791 дугаартай, гурван өрөө, орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг Ард Пропертиз ХХК-д 347,211,000 (гурван зуун дөчин долоон сая хоёр зуун арван нэгэн) төгрөгөөр худалдан аван борлуулахыг зөвшөөрсүгэй.
2. Үл хөдлөх хөрөнгө худалдах төлбөрийн нөхцөлийг Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1, 2 дугаар заалтад нөхцөлөөр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулж, компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.
4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ